

БАТЛАВ.
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Л.МӨНХБААТАР

2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа- 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх зорилтыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ”, “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ”, “Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинэ”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дунджаар 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж заасан.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгох,

хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик шаардлага

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь дэлхийн улс орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэрэглээний татвар юм. Тус татварын тогтолцоо нь үйлдвэрлэлийн үе шат бүрд нэмүү өртөг ногдуулж, эцсийн хэрэглэгч болох иргэд хэрэглээндээ төлдөг бөгөөд аж ахуйн нэгжүүдийн хувьд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлсөн татварыг суутган авч түүнээс өөрсдийн худалдан авалтдаа төлсөн татварыг хасаж төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлдог.

Олон Улсад Шинэ Зеланд Улсыг татварын бааз суурь хамгийн өргөн гэж онцолдог ба тус улс нь бүх бараа, үйлчилгээнд нэг ижил татварын хувь хэмжээгээр татвар ногдуулж, татварын чөлөөлөлтийг хамгийн бага түвшинд байлгаснаар бүх нийтээрээ татварыг жигд, шударга төлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2007, 2015 онд шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэйгээр төгрөгийн ханш суларч, инфляц, хүүгийн түвшин нэмэгдсэн тул голчлон бага, дунд орлоготой хувь хүн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал нэн чухал ач холбогдолтой болж байна. Иймд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлага бий болж байна.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болж, Монгол Улсын инфляцын түвшин 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 8.2 хувьд хүрсэн ба энэ нь голчлон бага дунд орлоготой иргэн, өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж, тэдний бодит орлого, худалдан авах чадварыг бууруулж, орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна.

Монгол Улсад 2024 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 58 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалд, 29 хувь буюу 30 мянга гаруй аж ахуйн нэгж алдагдалтай ажилласан нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурах, санхүүгийн дарамтад орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалахад хүндрэл үүсгэж байгааг харуулж байна. Иймээс дээрх нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор татварын бодлогын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Түүнчлэн, өнгөрсөн 2024 оны байдлаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хувийн буцаан олголтын хөнгөлөлтөөр нийт 346 тэрбум төгрөгийг 1.4 сая иргэнд олгосон байна. Үүнээс нийт иргэдийн өндөр худалдан авалт хийдэг 25 хувь нь нийт хөнгөлөлтийн 75 хувийг авсан байгаа нь өнөөгийн хэрэгжиж буй нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын оновчтой, хүртээмжтэй

байдлыг сайжруулах, татварын бодлогыг нийгмийн жигд, шударга байдлыг дэмжих чиглэлд сайжруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт татвар тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд татварын эдийн засгийн гол зарчим болох шударга байх зарчмыг баримтална гэж заасан байдаг. Тус зарчим нь татвар төлөгчийн хөрөнгө, орлого, хэрэглээний хэмжээнээс хамаарч төлбөл зохих татварыг ялгаатай тогтоох агуулгыг илэрхийлэх бөгөөд энэхүү зарчмыг шаталсан татварын тогтолцоогоор хэрэгжүүлдэг нийтлэг жишигтэй.

"Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар дүгнэлтээр шаталсан татварын тогтолцоо нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчимд нийцэж буйг онцолсон. Тус дүгнэлтэд татварын ачааллыг иргэдийн орлогын хэмжээ, төлөх чадавхтай уялдуулан шударгаар хуваарилах, орлого өндөр байхын хэрээр татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх нь орлогын ялгааг бууруулах, баялгийн төвлөрлийг сааруулах, бага орлоготой иргэдийн татварын дарамтыг хөнгөвчлөх, эдийн засгийн өсөлтийг тэнцвэртэй хангах зэрэг эерэг үр нөлөөтэй болохыг тодорхойлжээ.

Монгол Улсын Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үр дүнд бүх нийтээрээ жигд, шударга төлдөг татварын тогтолцоог бүрдүүлэх, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг шууд хасах, ажил эрхлэлтийг дэмжсэн хөшүүргийг бий болгох, орлого хүлээн зөвшөөрөх суурь зарчмыг өөрчлөх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан, ойлгомжтой болгох, бүх нийтээрээ жигд, шударга төлдөг тогтолцоог бүрдүүлж, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн оновчтой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэх практик шаардлага үүсэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь бүх нийтээрээ жигд, шударга төлдөг тогтолцоог бүрдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, тулгарч буй асуудлыг нэг мөр шийдэх, орлогын тэгш бус байдлыг бууруулах, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлогын оновчтой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх мөн татвар төлөгчдөөс татварын хууль тогтоомжийг сайжруулахтай холбоотойгоор ирүүлсэн нийтлэг саналуудыг тусгахад чиглэнэ.

➤ Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах, бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох

1.Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олон улсын чиг хандлага, зарчимд нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй байдлыг сайжруулах замаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийг шаталсан хэлбэрээр нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

2.Бүх нийтээрээ жигд, шударга төлдөг тогтолцоог бүрдүүлэх зорилгоор үйл ажиллагаа эрхлэх хувь хүн, хуулийн этгээд бүгд нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгч болох бөгөөд жилийн үйл ажиллагааны борлуулалтын орлого нь 400 сая төгрөгөөс бага татвар төлөгч нь хялбаршуулсан горимоор татвараа тайлагнаж, төлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

3.Үйлдвэрлэл эрхлэгчдэд худалдан авалтыг бэлэн бусаар хийсэн тохиолдолд үнийн дүнд НӨАТ шингэсэн гэж үзэж, төлбөл зохих татвараас хасагдах эрхийг нээнэ.

4.Аж ахуйн нэгжүүдийн хууль даган мөрдөлтийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан дотоод болон импортын НӨАТ-ын төлбөрийг хоёр сар хүртэл хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүлж, аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал, уян хатан байдлыг дэмжинэ.

5.Үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн болон оршин суугч бус этгээдээс авсан ажил, үйлчилгээний НӨАТ-ыг хасалт хийх боломжийг бүрдүүлнэ.

6.Ажилчдын хөгжил, хүний нөөцийн бодлогыг дэмжих, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

7.Гадаад улсаас Монгол Улсад оршин суугч этгээдэд цахимаар үзүүлж буй үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулж, тэдгээрийг суутган төлөгчөөр бүртгүүлэх зохицуулалтыг тусгана.

8.Өндөр үнэлгээ бүхий суудлын автомашинд татвар ногдуулах, тодорхой босго дүнгээс дээш үнэлгээ бүхий орон сууцны чөлөөлөлтийг зогсоох зохицуулалтыг тусгана.

➤ Хуулийн төсөл нь 8 бүлэг, 25 зүйлээс бүрдэх бөгөөд дараах агуулгатай байна:

- Нийтлэг үндэслэл;
- Татвар төлөгч, түүнд үзүүлэх хөнгөлөлтийн талаар;
- Татвар суутган төлөгч, түүний бүртгэлийн талаар;
- Татвар ногдуулах харилцаа, татварын хувь болон чөлөөлөлтийн талаар;
- Худалдан авалтад төлсөн татварын хасалт, татварын эцсийн тооцоо хийх зохицуулалтын талаар;
- Татвар тайлагнах, төлөх болон буцаан олгох харилцааны талаар;
- Татварын хялбаршуулсан горим, гадаад улсаас цахимаар үзүүлсэн үйлчилгээг зохицуулах тусгайлсан харилцааны талаар;
- Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлуудыг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, орлогын тэгш бус байдал буурч, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн ачааллыг бууруулж, бизнесийн идэвхжих, тэлэх бололцоог ханган, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлэх ба бүх нийтээрээ жигд, шударга төлдөг татварын тогтолцоог бүрдүүлж, татварын хамрагдалтыг нэмэгдүүлэн, далд эдийн засгийг бууруулна. Цаашид хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан системийг нэвтрүүлснээр татвар төлөгчид шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авч, татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой асуудлуудыг урьдчилан шийдвэрлэж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, нийгэм, эдийн засагт эергээр нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулсан бөгөөд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---